



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2016 оны 01 сарын 18 өдөр

Дугаар 21

Улаанбаатар хот

Олимпийн наадамд бэлтгэн оролцуулах  
ажлыг эрчимжүүлэх тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 14.4 дэх хэсгийг үндэслэн, Эрүүл мэнд, спортын сайдын “Хөтөлбөр батлах тухай” 2016 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 15 дугаар тушаал, “Ажлын хэсэг байгуулах тухай” 2016 оны 01 дүгээр сарын 18 өдрийн 20 дугаар тушаалыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. “Рио-2016 хөтөлбөр”, “Пенчён-2018 хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хангаж өвөл, зуны олимпийн наадамд Монгол Улсын Үндэсний шигшээ багийг амжилттай бэлтгэн оролцуулах ажлыг эрчимжүүлэх зорилгоор Эрүүл мэнд, спортын яамны харъяа Биеийн тамир, спортын хөгжлийн төвийн төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангаж ажиллахыг Олимпийн наадамд бэлтгэх ажлын хэсгийн дарга, Эрүүл мэнд, спортын яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Ламбаад зөвшөөрсүгэй.

2. Өгөгдсөн үүрэг, даалгаврын биелэлтийн явцын талаар тогтмол мэдээлж, Олимпийн наадамд бэлтгэх үндэсний хорооны хурлыг 2016 оны нэгдүгээр улиралд багтаан зохион байгуулахыг Олимпийн наадамд бэлтгэх ажлын хэсэг (С.Ламбаа)-т үүрэг болгосугай.

САЙДЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ

Ц.ОЮУНБААТАР

080081

143